

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРХИВЫН ТАСАГ
(Лавлагаа хүсэгчдэд зориулсан товч лавлах)

Аймгийн архивын тасаг нь байгууллага, иргэдийн хүсэлтээр хадгаламжийн сангийн баримтаас доорх асуудлаар лавлагаа хуулбар олгох бөгөөд уншлагын танхимаар судлуулна. Үүнд:

- 1. Ам бүлийн тодорхойлолт, төрсөн он, нас*
- 2. Ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн, шагнагдсан тухай хуулбар*
- 3. Цалингийн тодорхойлолт, ажиллаж байсныг нотлох баримтын лавлагаа*
- 4. Гэрчилгээ, аттестатын хуулбар,*
- 5. Тухайн байгууллага, салбар, нэгжийн түүхэн танилцуулга*
- 6. Барилгын зураг, төсөв, ашиглалтад оруулсан акт, засварын талаар*
- 7. “Алдарт-Эх”-ийн одонгоор шагнагдсан тухай*
- 8. Өмч хувьчлалтай холбоотой асуудлаарх хуулбар, лавлага*

Манайхаар үйлчлүүлэхийг хүссэн та ямар асуудлаар лавлагаа хуулбар авах тухайгаа архиваас олгох өргөдлийн хуудсанд загварын дагуу тодорхой бичих, уншлагын танхимаар үйлчлүүлэх анкет бөглөх шаардлагатай.

*Архивын Ерөнхий газрын даргын 2015 оны А/168 Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифт зааснаар лавлагаа хуулбарын үнийг тарифын дагуу АЗДТГазрын **100051001** дансанд төлбөрийг тушаана.*

Та доорхи материалыг бүрдүүлж ирвэл та бидний ажил хөнгөн шуурхай бүтэмжтэй болно.

***Нэг:** Хүн амын тооллогын баримтуудаас лавлагаа, хуулбар олгоход шаардагдах баримт.*

***а)** Иргэний үнэмлэх*

***б)** Тухайн үед засаг захиргааны ямар нэгжид амьдарч байсныг тодорхой мэдэх.*

(1929.1944.1956.1966.2000 онуудад)

***в)** Өрхийн тэргүүний овог нэр*

Хоёр: Байгууллагын даргын тушаалын баримтуудаас лавлагаа хуулбар олгоход шаардагдах баримт: **а)** Иргэний үнэмлэх

б) Хөдөлмөрийн дэвтэр

в) Нийгмийн даатгалын дэвтэр

Гурав: Одон медаль болон “Алдарт-Эх”-ийн одонгийн лавлагаа, хуулбар олгоход шаардагдах баримт:

а) Аймаг, сум, овог нэр тодорхой байх

б) Одон авсан огноо

(5.8 дахь хүүхдийн төрсөн оныг тодорхойлох нотлох баримт)

Дөрөв: Татан буугдсан болон хувьчлагдсан байгууллагын цалингийн тодорхойлолтын лавлагаа, хуулбар олгоход шаардагдах бичиг баримт

а) Иргэний үнэмлэх

б) Хөдөлмөрийн дэвтэр

в) Нийгмийн даатгалын дэвтэр **г)** Нэгдлийн гишүүд өрхийн тэргүүний овог нэр тодорхой байх

Тав: Банкны баримтаас лавлагаа, хуулбар олгоход шаардагдах баримт:

а) Иргэний үнэмлэх

б) Банкны байгууллагуудын албан бичиг

Зургаа: Нотариатын баримтаас лавлагаа, хуулбар олгоход шаардагдах бичиг

а) Иргэний үнэмлэх

б) Баталгаажуулсан нотариатчийн зөвшөөрсөн албан бичиг

Долоо: Эрүүгийн хавтаст хэргийн баримтуудаас

а) Улсын дээд шүүхийн албан бичиг **б)** Улсын Ерөнхий Прокурорын газрын албан бичиг

в) Шүүх, Цагдаагийн байгууллагын албан бичиг

Найм: Иргэний хавтаст хэргийн баримтуудаас **а)** Хариуцагч, нэхэмжлэгчийн хувийн өргөдөл